



ЧИЙГШҮҮЛЭГЧТЭЙ СЭНС АЕ-Н9

АШИГЛАЛТЫН ЗААВАР



Энэхүү бүтээгдэхүүнийг хэрэглэхийн өмнө ашиглалтын заавартай сайтар танилцана уу.

ДҮРСТ ТЭМДЭГЛЭЛҮҮДИЙН ТОДОРХОЙЛОЛТ:



Европын Холбооны чанарын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүнд олгогддог тэмдэг



Зэрэглэл II тэмдэглэл: Тус төхөөрөмж нь давхар тусгаарлагчтайгаар бүтээгдсэн. Иймд түүнийг газардуулагчтай холбох шаардлагагүй.



Усны савыг 3 хоног тутам цэвэрлэ.



Хориглосон хогийн савны тэмдэглэл нь ахуйн хог хаягдлаас тусад нь ялгаж хаяхыг илэрхийлнэ. Төхөөрөмжийн бүрдэл хэсгүүдийг дахин боловсруулалтанд зориулж байгаль орчны хууль дүрмийн дагуу ангилж, зориулалтын саванд хаяна. Ахуйн хог хаягдлаас ялгаж, ангилснаар та хог хаягдлын хэмжээг бууруулах, байгаль орчны болон иргэдийн эрүүл мэндийн эсрэг нөлөөллийг бууруулах хувь нэмэрээ оруулах болно.

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ:

Уг цахилгаан төхөөрөмжийг ашиглах үедээ аюулгүй ажиллагааны зөвлөмжийг мөрдөж ажиллуулна!

1. Төхөөрөмжийг хэрэглэхийн өмнө хэрэглэгч уг ашиглалтын зааврыг сайтар уншиж танилцах ёстой.
2. Төхөөрөмжийг 220-240V~ 50 Hz цахилгаанд холбож ажиллуулна.
3. Зөвхөн гэр ахуйн хэрэгцээнд, дотоод орчинд хэрэглэнэ.
4. Бүрэн угсрагдсан нөхцөлд ажиллуулна.
5. Төхөөрөмжийг түүний бүхий л функц, чиг үүргүүд нь бүрэн ажиллаж байгаа нөхцөлд ашиглана. Хэрэв төхөөрөмж унасан, эвдэрсэн, зарим бүрдэл хэсэг нь бүрэн бус ажиллаж байгаа бол унтрааж, мэргэжлийн байгууллагаар засварлуулж дууссаны дараа ажиллуулна.
6. Хүүхэд болон бие даан төхөөрөмжийг хэрэглэх чадваргүй хэн нэгэн төхөөрөмжийг ажиллуулахыг оролдох, тоглох, ойртохыг хориглоно.
7. Төхөөрөмжийн цахилгааны ишнүүр нь зөв суурилагдсан залгуурын үүрт (разетка) холбогдоно.
8. Төхөөрөмжийн техникийн үзүүлэлтэнд заасан цахилгааны хүчдэл нь залгуурын үүрийн үзүүлэлттэй нийцсэн байна.
9. Төхөөрөмжийн цахилгааны ишнүүр, залгуурын үүртэй нойтон гараар харьцахыг хориглоно.

10. Цахилгааны утсыг нугалах, шахах, татахыг хориглох ба хурц эдлэл, тос болон халуунаас хамгаалах шаардлагатай.
11. Цахилгааны утсыг зөвхөн зориулалтын дагуу ашиглана.
12. Хэрэв цахилгааны утас гэмтсэн байвал залгуураас нь шууд салгана.
13. Төхөөрөмжийг ашиглахгүй бол залгуураас нь салгана.
14. Төхөөрөмжийг зөөх, тээвэрлэхээс өмнө залгуураас салгана.
15. Сэнс ажиллаж байгаа үед сэнсны торны завсар ямар нэг зүйл шургуйлж, хийж болохгүй.
16. Үргэлж хавтгай гадарга дээр төхөөрөмжийг байршуулна.
17. Төхөөрөмжийн хүрээлж буй орчин нь тэсэрч дэлбэрэх, шатах материалаас ангид байх ёстой.
18. Сэнсний ойролцоо алчуур, хувцас гэх мэт эд зүйлс тавихыг хориглоно. Эдгээр нь сэнс рүү орж, эргэлдэх хөдөлгөөнд саад учруулж, төхөөрөмжийн эд ангийг эвдэх, бусдад гэмтэл учруулж болзошгүй.
19. Төхөөрөмжийг үндсэн залгуурт залгахаас өмнө сэнс, чийгшүүлэгч нь OFF горимд байна.
20. Төхөөрөмжийг ажиллуулж байгаа үед харгалзах хүнгүйгээр орхихыг хориглоно. Хэрэв өрөөнөөс гарах бол төхөөрөмжийг үндсэн залгуураар нь цахилгаанаас салгаж явна уу.
21. Хэрэв төхөөрөмжийг ажиллуулаагүй байх, мөн ус хийх, цэвэрлэх, засвар хийхийн өмнө заавал үндсэн залгуураар нь цахилгаанаас салгах ёстой.
22. Төхөөрөмжийн орчмын талбайг хэт чийглэг, нойтон болгохоос зайлсхий. Хэт чийглэг орчин нь төрөл бүрийн нян, бактери өсөж үржих таатай нөхцөл болдгийг анхаарна уу. Хэрэв чийглэгийн хувь хэмжээ доошоо буухгүй бол чийгшүүлэгчийг нь унтрааж, дан сэнсийг нь ажиллуулж болно.
23. Чийгшүүлэгчийн саванд ус хийх, цэвэрлэх үедээ төхөөрөмжийг унтраана.
24. Төхөөрөмжийг хэрэглээгүй үедээ чийгшүүлэгчийн саванд байх усыг асгаж, хоосон байлгана уу.
25. Удаан хугацаанд хэрэглэхгүй бол чийгшүүлэгчийн савыг суллан цэвэрлэж, дараагийн хэрэглээнд бэлтгэнэ.
26. Чийгшүүлэгчийн саванд байх усыг тогтмол солихгүй байх, удаан хугацаанд устай байлгах нь усанд төрөл бүрийн бактери үржих таатай нөхцөл болдог ба чийгшүүлэгчийг нь ажиллуулж, удсан усыг гадагшлуулснаар өрөөний

агаарт хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй хөгц, бактери бий болох нөхцөл үүснэ. Иймд 3 өдөр тутам чийгшүүлэгчийн савыг суллах, цэвэрлэх шаардлагатай.

27. Чийгшүүлэгчийн саванд ус хийхээс өмнө савны доор байх чийгшүүлэгчийн суурь хэсгийг сайтар цэвэрлэж, хуурай алчуураар арчина.

28. Ус чийгшүүлэгчийн саванд ямар нэг амин тос /essential oil/, үнэр гаргах бүтээгдэхүүн хийхийг хориглоно.


ХЭРЭГЛЭЭНД БЭЛТГЭХ:

Чийгшүүлэгчтэй сэнс АЕ-Н9 загварыг хэрэглэхийн өмнө:

- Сэнсийг гадна хайрцагнаас нь гаргаж, бүх зөөлөвч, уутнаас нь бүрдэл хэсгүүдийг гаргаж, угсрахад бэлэн болгоно.
- Төхөөрөмжийг тэгш, тогтвортой гадарга дээр байрлуулна.
- Тээвэрлэлт, баглалтын явцад үүссэн байж болох тоос шороог зөөлөн алчуураар цэвэрлэнэ.

БҮРДЭЛ ХЭСГҮҮД:

1. Холбох бүслүүр
2. Чийг гадагшлуулагч
3. Нүүрэн талын хамгаалалтын тор
4. Сэнсний далавчны бөхөлгөө
5. Сэнсний далавч
6. Хамгаалалтын торны бөхөлгөө
7. Ар талын хамгаалалтын тор
8. Сэнсний толгой/мотор
9. Чийгшүүлэгчийн хоолой
10. Шурга /шруп/
11. Их бие
12. Нэмэлт хүндрүүлэгчтэй суурь тавцан
13. 4 дугуй
14. Суурь тавцангийн бөхөлгөө
15. Усны сав



УГСРАЛТ:


1. Гадна хайрцаг, түүнд байх бүх зөөлөвч, уутнаас нь сэнсний бүрдэл хэсгүүдийг гаргаж, угсрахад бэлэн болгоно.
2. Их бие (11)-ийн дээд талд байх дугуй нүх рүү сэнсний толгой (8)-н холбоос төмөр хоолойг хийнэ. Төмөр хоолойн доод хэсэгт байх шруппы нүх нь их биеийн төмөр хоолой орох хэсэгт байх жижиг шруп (10)-тэй нэг байрлалд орсон үед шрупыг чангалж их бие, сэнсний толгойг хөдөлгөөнгүй болгоно. Зарим тохиолдолд их бие, сэнсний толгойг холбодог хар цахилгааны утас нь эрчилж, орооцолдсон байдаг тул сэнсний толгойг эргүүлж эрчилгээг нь гаргана.
3. Суурь тавцан (12)-гийн цагаан талыг эргүүлэн доош харуулахад нөгөө талд нь хүндрүүлэгч хар хавтан байна. 4 дугуй (13)-ны метал толгой руу 4 хар пластик углуургыг хийж хар хавтанд байрлах 4 нүх рүү хийнэ.
4. Их бие (11)-ийн доод талд байрлах суурь тавцангийн бөхөлгөөг (14) эргүүлээд тайлж ав. Суурь тавцангийн (12) цагаан өнгийн нүүртэй тал дээр их биеийг суурилуулна. Суурь тавцангийн доод талаас суурь тавцангийн бөхөлгөөг (14) их биеийн доод хэсэгтэй буцааж чангалж хийснээр их бие, суурь тавцан холбогдож хөдөлгөөнгүй болно.
5. Сэнсний их бие бүхэлдээ угсрагдаж, босоо байрлалд байна. Одоо сэнсний толгойг угсрай. Сэнсний толгой/ моторын (8) гол дээр хамгаалалтын торны бөхөлгөө (6), сэнсний далавчны бөхөлгөө (4) байгаа бол суллаж авна. Сэнсний далавчны бөхөлгөөг (4) авахдаа НАР ЗӨВ ЭРГҮҮЛЖ суллана.
6. Эхлээд ар талын хамгаалалтын торыг (7) сэнсний толгойн иш дээр байрлуулж, хамгаалалтын торны бөхөлгөө (6)-гөөр чангална. Дараа нь сэнсний далавч (5)-ийг сэнсний толгойн иш дээр байрлуулна. Ишны үзүүрийн 2 тийшээ гарсан жижиг төмөр хошуу сэнсний далавчны гол хэсэгт зөв суусан байх ёстой. Тэгээд сэнсний далавчны бөхөлгөө (4)-г хийж чангална. Чангалахдаа НАР БУРУУ ЭРГҮҮЛНЭ.
7. Холбох бүслүүрийн (1) шургийг отвёркагаар бага зэрэг суллана. (Зөвхөн 2-3 удаа эргүүлнэ.)
8. Нүүрэн талын хамгаалалтын тор (3)-ны ирмэгийг ар талын хамгаалалтын тор (7)-ны ирмэгтээ чацуулан байрлуулна. Хоёр хамгаалалтын торны ирмэг дээр холбох бүслүүр (1)-ийг тааруулж байрлуулаад холбох бүслүүрийн шургийг чангална.
9. Нүүрэн талын хамгаалалтын торон (3) дээр байрлах чийг гадагшлуулагч (2)-ийн нүх рүү чийгшүүлэгчийн хоолойг (9) хийнэ.

АНХААРАХ:

- Сэнсний далавч, тор нь бүрэн, зөв суурилагдах хүртэл сэнсийг ажиллуулж болохгүй!!!

СЭНСНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА:


Төхөөрөмжийг цахилгаантай холбоход ажиллахад бэлэн төлөвт (Stand by) шилжиж гэрэл асна. Сэнсийг мэдрэгч дэлгэцээр гараараа болон алсын удирдлагаар удирдана. Алсын удирдлагад 2 ширхэг AAA 1.5V батарей орно. Чийгшүүлэгчийн савыг усаар дүүргэсний дараа цахилгаанд залгана.



АНХААРАХ!

- Усны саванд ус хийхээс өмнө төхөөрөмжийн цахилгааны ишнүүрийг залгуурын үүрээс (разетка) салгасан байх ёстой.
- Усны саванд зөвхөн ус хийнэ. Ямар нэгэн химийн бодис, амин тос, бусад нэмэлтүүд хийж болохгүй.
- Усны саванд зөвхөн хүйтэн, бүлээн ус хийнэ. Ус нь 40°C-ээс дээш халуун бүлээн байж болохгүй.

ДЭЛГЭЦИЙН АЖИЛЛАГАА



МЭДРЭГЧ ДЭЛГЭЦЭЭР УДИРДАХ:

1.Сэнс ажиллах:

- Сэнс ажиллуулахын тулд “Сэнс ажиллах, салхины хурд” товчыг дарна
- Сэнсний хурдыг (Сул, дунд зэрэг, хүчтэй) тохируулахын тулд “Сэнс ажиллах, салхины хурд” дээр дараалан дарна.
- Сэнс унтраахын тулд “Сэнс унтраах” товчин дээр дарна.

2. Эргэх хөдөлгөөн (2 тал руу):

- Эхлээд сэнсийг ажиллуулна. Дараа нь “Эргэх хөдөлгөөн” товчыг дарна. Чийгшүүлэгчтэй сэнсний толгой 45 градусын эргэлтийн өнцөгөөр 2 тал руу эргэнэ. “Эргэх хөдөлгөөн” товчыг ахин дарахад эргэх хөдөлгөөн тухайн дарсан байрлалдаа зогсоно.

3. Дээшээ, доошоо хазайлгах:

- Сэнсний толгойг сайтар барь. Сэнсний толгойн баруун талд байх далавчит бариулыг буруу тийш эргүүлнэ. Сэнсний толгойг дээшээ, доошоо тохиромжит байрлал руу хөдөлгөнө. Байрлалаа тохируулсны дараа бариулыг буцаагаад чангална.



4. Чийгшүүлэгчийг хэрэглэх

- Чийгшүүлэгчийг ажиллуулах, унтраахын тулд “Чийгшүүлэгч АЖИЛЛАХ/УНТРААХ” товчыг дарна.

5. Цагийн тохиргоо хийх

- Хэрэв сэнс ажиллаагүй үед “Цагийн тохиргоо” товчыг дарвал дэлгэцэн дээр сэнс ажиллаж эхлэх хүртэлх цагийг заана. 1-12 цагийн тохиргоотой.
- Хэрэв сэнс ажиллаж байгаа үед “Цагийн тохиргоо” товчыг дарвал дэлгэцэн дээр сэнс унтрах хүртэлх цагийг заана. 1-12 цагийн тохиргоотой.

6. Салхины гормын тохиргоо

- Салхины горимын тохиргоог зөвхөн алсын удирдлагын тусламжтайгаар гүйцэтгэнэ.
- Алсын удирдлагын “Mode” товчин дээр дарж салхины горим (энгийн шөнийн, байгалийн) өөрчлөнө.

7. Унтраах


- Сэнс нь “Сэнс унтраах” товчин дээр дарснаар унтарна.

АЛСЫН УДИРДЛАГА:

Чийгшүүлэгч АСАХ /УНТРАХ

Цагийн тохиргоо АСАХ/УНТРАХ 1-12 цаг

Сэнс АСАХ/УНТРАХ, Сэнсний хурд



Салхины горим

Сэнс унтраах

Эргэлт АСАХ/УТРААХ

ЦЭВЭРЛЭГЭЭ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ:

Цэвэрлэгээ:

- Цэвэрлэхийн өмнө сэнсийг цахилгаанаас нь салгана.
- Төрөл бүрийн нян бактери, хөгц үүсэхээс сэргийлэхийн тулд 3 хоног тутам усны сав болон чийгшүүлэгчийн суурийг цэвэрлэнэ.
- Хэрэв удаан хугацаанд сэнсийг ашиглахгүй бол усны сав болон чийгшүүлэгчийн суурь дахь усыг нь асгаж, зөөлөн даавуугаар хуурай болтол арчина.
- Хэрэв удаан хугацаанд (өвлийн улиралд г.м) ашиглахгүйгээр шийдэж, агуулахдаа хадгалах гэж байгаа бол сэнсний чухал бүрдэл хэсгүүд рүү тоос, тоосонцор орохоос сэргийлж тохиромжтой уут, саванд хийнэ.
- Төхөөрөмжийн пластик бүрхүүл, мэдрэгч дэлгэцийг эвдрэхээс сэргийлж, ямар нэг химийн хольцтой цэвэрлэх шингэн, зүлгүүр хэрэглэхээс зайлсхий.

Засвар, үйлчилгээ:

Төхөөрөмж хэрэглэгчид очихдоо үйлдвэрээс шууд ирсэн задлаагүй хайрцагтай ирнэ. Борлуулагч ажиллагааны бүрэн бүтэн байдлыг шалгасан бол хэрэглэгчид энэ тухай мэдэгдэнэ. Хайрцагт алсын удирдлагад орох 2 ширхэг AAA 1.5V батарей зай хийгдээгүй болно.

Засвар үйлчилгээ

Борлуулагчаас өгөх баталгаат хугацаанд үйлдвэрлэлийн гаралтай гэмтэл согогтой бүтээгдэхүүн гарсан бол үнэ төлбөргүй засвар үйлчилгээг хийж гүйцэтгэнэ.

Хог хаягдал

Төхөөрөмжийг энгийн хог хаягдлын хамтаар хаяж болохгүй. Түүний бүрдэл хэсгүүдийг дахин боловсруулалтанд зориулж байгаль орчны хууль дүрмийн дагуу ангилж, зориулалтын саванд хаяна. Ахуйн хог хаягдлаас ялгаж, ангилснаар та хог хаягдлын хэмжээг бууруулах, байгаль орчны болон иргэдийн эрүүл мэндийн эсрэг нөлөөллийг бууруулах хувь нэмэрээ оруулах болно.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ:

Асуудал	Шалтгаан	Шийдэл
“Stand by” горим дээр байх сэнс унтраах товчны гэрэл асахгүй байх, үүнээс улбаатай сэнс, чийгшүүлэгч ажиллахгүй байх.	Төхөөрөмж цахилгаанд бүрэн холбогдоогүй байх.	Цахилгаанд бүрэн залгах
Чийгшүүлэгч ажиллахгүй байх.	Усны саванд ус байхгүй байх. Усны савны пүрштэй хавхлаг доош түлхэгдсэн байх.	Ус хийх. Гарын хуруугаараа пүрштэй хавхлагийг зөөлхөн оролдож, дээш нь, хэвийн түвшинд аваачих.
Чийгшүүлэгчээс эвгүй үнэр гарах	Усны сав цэвэр биш байх.	Усны сав, чийгшүүлэгчийн суурийг цэвэрлэх, Шинэ ус хийх.
Усны савны дэлгэцийн гэрэл ассан, гэхдээ сэнс, чийгшүүлэгч ажиллахгүй байх.	Усны түвшин хэт их байх.	Зарим усыг нь асгах.
Маш багаар чийгшүүлэх	Чийгшүүлэгчийн суурийн ууршуулагч бохирдсон байх.	Чийгшүүлэгчийн суурийг цэвэрлэх.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ:

Загвар.	АЕ-Н9
Цахилгаан хүчдэл (V/Hz)	220-240V~ 50 Hz
Эрчим хүчний хэрэглээ	75W
Усны багтаамж	2 л
Усны хэрэглээ	<250мл/цаг

ERP TEST DATA:

Description	Symbol	Value	Unit
Maximum fan flow rate	F	38.64	m ³ /min
Fan power input	P	48.23	W
Service value	SV	0.80	(m ³ /min)/W
Standby power consumption	PSB	0.30	W
Seasonal electricity consumption	Q	15.77	kWh/a
Fan sound power level	LWA	60.09	dB(A)
Maximum air velocity	c	2.44	meters/sec
Test standard(s) or criteria(s)	(EU) No 206/2012 + (EU) 2016/2282 IEC 60879:1986/COR1:1992 EN 50564:2011 EN 60704-1:2010+A11:2012 EN IEC 60704-2-7:1998		

ЭКО АГААР, ЭРҮҮЛ АМЬДРАЛ